

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газрын
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2025/50/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Говьсүмбэр аймаг 2025 он	Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Дарханбат Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
 - ..
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох аудит
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Б.БОЛД-ЭРДЭНЭ ТАНАА

2025.02.19 № 40

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

422502077

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 45 арга хэмжээ бүхий ажил, үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжүүлэн ажилласан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 87.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	3,017,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	3,017,000.00
354	Хангамжийн материал	0.00	3,017,000.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	1,229,000.00
35420	Аж ахуйн материал	0.00	1,508,000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	280,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	29,597,721.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	29,597,721.35
392	Биет хөрөнгө	0.00	23,739,388.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	8,560,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(7,490,000.07)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	24,323,033.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(8,154,642.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	9,345,550.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(2,844,552.74)
393	Биет бус хөрөнгө	0.00	5,858,333.27
39301	Програм хангамж	0.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(500,000.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	5,500,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(641,666.69)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	32,614,721.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	32,614,721.35
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	32,614,721.35
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	32,614,721.35
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	32,614,721.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	32,614,721.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	292,069,935.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	24,229,060.9
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	24,229,060.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	24,229,060.9
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	24,229,060.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	267,840,875.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	12,740,875.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	8,890,875.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	3,850,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	255,100,000.0

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	255,100,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	259,455,214.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	259,455,214.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	188,366,345.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	144,429,174.2
210101	Үндсэн цалин	0.00	82,158,187.9
210102	Нэмэгдэл	0.00	43,915,986.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	5,715,000.0
210104	Урамшуулал	0.00	12,640,000.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	15,911,126.1
210201	Тэтгэврийн даатгал	0.00	10,701,723.5
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	1,443,582.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	721,791.4
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	608,805.6
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	2,435,222.6
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	8,181,251.5
210401	Бичиг хэрэг	0.00	1,690,200.0
210402	Тээвэр, шатахуун	0.00	5,048,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	626,851.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	727,550.0
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	0.00	88,650.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1,339,900.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,339,900.0
2107	Томилолт, зочны зардал	0.00	4,718,000.0
210702	Дотоод албан томилолт	0.00	4,718,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	260,604.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	3,200.0
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	119,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	115,904.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	22,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	13,526,289.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	619,300.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	1,050,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	11,856,989.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	71,088,869.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	10,082,875.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	8,890,875.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,192,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	61,005,994.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	61,005,994.3
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	32,614,721.4
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	32,614,721.4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	267,840,875.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	267,840,875.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	12,740,875.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	8,890,875.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	3,850,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	255,100,000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	255,100,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	249,551,075.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	249,551,075.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	178,462,205.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	144,429,174.2
210101	Үндсэн цалин	0.00	82,158,187.9
210102	Нэмэгдэл	0.00	43,915,986.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	5,715,000.0
210104	Урамшуулал	0.00	12,640,000.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	15,911,126.1
210201	Тэтгэврийн даатгал	0.00	10,701,723.5
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	1,443,582.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	721,791.4
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	608,805.6
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	2,435,222.6
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	9,741,601.5
210401	Бичиг хэрэг	0.00	2,919,200.0
210402	Тээвэр, шатахуун	0.00	5,198,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	626,851.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	997,550.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1,469,900.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,469,900.0
2107	Томилолт, зочны зардал	0.00	4,718,000.0
210702	Дотоод албан томилолт	0.00	4,718,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	260,604.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	3,200.0
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	119,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	115,904.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	22,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,931,800.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	881,800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	1,050,000.0

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	71,088,869.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	10,082,875.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	8,890,875.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,192,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	61,005,994.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	61,005,994.3
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	18,289,800.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	18,289,800.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	18,289,800.0
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	18,289,800.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	18,289,800.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-18,289,800.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00

D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	32,614,721.35	0.00	32,614,721.35
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	32,614,721.35	0.00	32,614,721.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	255,100,000.0	194,256,905.7	60,843,094.29	76%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	255,100,000.0	194,256,905.7	60,843,094.29	76%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	253,700,000.0	193,064,905.7	60,635,094.29	76%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,440,000.0	144,429,174.2	48,010,825.85	75%
210101	Үндсэн цалин	107,420,000.0	82,158,187.9	25,261,812.13	76%
210102	Нэмэгдэл	60,730,000.0	43,915,986.3	16,814,013.72	72%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,820,000.0	5,715,000.0	3,105,000.00	65%
210104	Урамшуулал	15,470,000.0	12,640,000.0	2,830,000.00	82%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,660,000.0	15,911,126.1	9,748,873.94	62%
210201	Тэтгэврийн даатгал	17,440,000.0	10,701,723.5	6,738,276.47	61%
210202	Тэтгэмжийн даатгал	2,040,000.0	1,443,582.9	596,417.14	71%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,020,000.0	721,791.4	298,208.58	71%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,020,000.0	608,805.6	411,194.36	60%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,140,000.0	2,435,222.6	1,704,777.39	59%
2104	Хангамж, бараа материалын зардал	7,130,000.0	6,804,501.5	325,498.50	95%
210401	Бичиг хэрэг	1,230,000.0	1,182,100.0	47,900.00	96%
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.0	3,998,000.0	2,000.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.0	626,851.5	273,148.50	70%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.0	997,550.0	2,450.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,000,000.0	12,759,700.0	240,300.00	98%
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.0	9,809,700.0	190,300.00	98%
210602	Тавилга	3,000,000.0	2,950,000.0	50,000.00	98%
2107	Томилолт, зочны зардал	4,905,000.0	4,718,000.0	187,000.00	96%
210702	Дотоод албан томилолт	4,905,000.0	4,718,000.0	187,000.00	96%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,165,000.0	7,260,604.0	1,904,396.00	79%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,149,300.0	5,503,200.0	1,646,100.00	77%
210803	Даатгалын үйлчилгээ	122,000.0	119,500.0	2,500.00	98%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	361,000.0	115,904.0	245,096.00	32%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,700.0	22,000.0	10,700.00	67%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.0	1,500,000.0	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.0	1,181,800.0	218,200.00	84%

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	900,000.0	881,800.0	18,200.00	98%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.0	300,000.0	200,000.00	60%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,400,000.0	1,192,000.0	208,000.00	85%
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,400,000.0	1,192,000.0	208,000.00	85%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.0	1,192,000.0	208,000.00	85%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	255,100,000.0	194,256,905.7	60,843,094.29	76%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	255,100,000.0	194,256,905.7	60,843,094.29	76%
122005	Орон нутгийн төсвөөс	255,100,000.0	194,256,905.7	60,843,094.29	76%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100%
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	7	5	2.00	71%
620001	Удирдах ажилтан	1	1	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	6	4	2.00	67%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	7	5	2.00	71%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	4	2	2.00	50%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3	-	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,740,875
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,577,975
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,687,100
2104	Хангамж, бараа материалын зардал	2,937,100
210401	Бичиг хэрэг	1,737,100
210402	Тээвэр, шатахуун	1,200,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	750,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,890,875
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,890,875
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,890,875
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	162,900
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	162,900
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,740,875
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,740,875
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,890,875
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,850,000

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 45 арга хэмжээ бүхий ажил, үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжүүлэн ажилласан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 87.9 хувьтай хэрэгжсэн гэж дүгнэгджээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2023 оны А/294 дүгээр захирамжаар Худалдан авах ажиллагааны газрыг 7 хүний орон тоотой байгуулсан.
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын дагуу “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ...” шинэчлэн тогтоогдсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд багтдаг, орон нутгийн төсвийн байгууллагуудын НБББББ-г мөрдөж ажилладаг байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах зөвлөмжийг өгсөн бөгөөд 2025 оноос шинээр батлагдсан бодлогын баримт бичгийг мөрдөхөөр шийдвэрлэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32,614.7 мянган төгрөгөөр буюу 100 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	0	3,017.0	3,017.0
Үндсэн хөрөнгө	0	29,597.7	29,597.7
Нийт хөрөнгө	0	32,614.7	32,614.7
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	0	32,614.7	32,614.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	0	32,614.7	32,614.7

Дээрх хүснэгтээс харахад дараах нөлөө бүхий дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна: Үүнд:

- Бараа материал дансанд Орон нутгийн өмчийн газраас балансаас баланст 934.1 мянга, НИК ХХК-иас урамшуулал 130.0 мянга, нийт 1,064.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого бүртгэж, байгууллагын төсвөөр 12,084.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч 88.6 мянган төгрөгийн бараа материалыг Орон нутгийн өмчийн газарт шилжүүлж, 10,043.1 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан байна.
- Үндсэн хөрөнгө дансанд АИТХ-ын даргын 2023 оны А/155-р захирамжаар 15,579.4 мянга, 2024 оны 29-р захирамжаар 2,466.2 мянга, 121-р захирамжаар 2,621.3 мянга, Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2,498.0 мянга, нийт 23,164.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй, байгууллагын төсвөөр 18,289.8 мянга, нийт 41,454.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол 11,857.0 мянган төгрөгөөр буурсан байна.
- Эздийн өмчийн данс нь 32,614.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь аймгийн Засаг даргын 2023.10.20 оны өдрийн А/294 дүгээр захирамжаар үүсгэн байгуулагдсан бөгөөд 2024 оны төсвийн төслийг бэлтгээгүй байна. Оны эхэнд 255,100.0 мянган төгрөг батлагдсан бөгөөд төсвийн тодотголоор зардлын бүлэг хооронд шилжүүлэг хийж, нэмж төсөв батлагдаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 255,100.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 194,256.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож 60,843.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 194,256.9 мянган төгрөг буюу 76.1 хувьтай байгаа нь төсвийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70418-80101	253,700.0	193,064.9	60,635.1	76.1%
5	70418-80802	1,400.0	1,192.0	208.0	85.1%
Нийт		255,100.0	194,256.9	60,843.1	76.1%

Зардлын хэмнэлтэд орон тоо дутуу ажилласан тул цалин хөлс, НДШ-ийн зардал 57,759.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын нэгдсэн судалгааны үр дүн:

1. Тус байгууллага ахмадын санд хөрөнгө төвлөрүүлээгүй байна.
2. Босго үнээс давсан худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.
3. Үндсэн үйл ажиллагааны 801010 арга хэмжээнээс 9.2 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг зарцуулсан бөгөөд зарцуулалттай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.
4. Үндсэн үйл ажиллагааны 801010 арга хэмжээнээс 619.3 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулсан бөгөөд зарцуулалттай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.
5. Тайлант онд 7 орон тоо, 192,440.0 мянган төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардал батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 5 орон тоотой ажиллаж, 144,429.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн

тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд 12,740.8 мянган төгрөгийг төвлөрүүлж зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- Тендерийн урилгын орлого 3,850.0 мянга, төрийн захиргааны албан хаагчид олгох тэтгэмжийн санхүүжилт 8,890.8 мянга, нийт 12,740.8 мянган төгрөгийн эх үүсвэр бүртгэж, хангамж бараа материал зардалд 2,937.1 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага 750.0 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох урамшууллын зардалд 8,890.8 мянга, нийт 12,577.9 мянган төгрөгийг зарцуулж, 162.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 20 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 255,100.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,805.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 2,663.8 мянган

төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баталсан байна.

Дээрх чиглэл, зааврыг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагад хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор Шилэн дансны цахим хуудсыг шалгахад дараа зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилт

1.1. Илрүүлэлт: Хөрөнгө зарцуулах 250.0 мянган төгрөгийн 1 тушаал, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсвийн байгууллагын батлагдсан төсвийн гүйцэтгэл-1 /7-р сард/, хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан тайлбар-1 /7-р сард/ хугацаа хоцорч мэдээлсэн. Мөн 5 сая төгрөгөөс дээш 5,105.0 мянган төгрөгийн 1 худалдан авалтыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.4 дахь “*таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг*; гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

1. Завсрын аудитаар материаллаг алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

1. Шинээр үүсгэн байгуулагдсан тул өмнөх онд аудитад хамрагдаагүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 31,175.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил¹ илэрсэн бөгөөд 31,089.0 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж 86.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон.

Залруулсан алдаа:

1. Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны 01 сарын 08-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авсан боловч санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон хуримтлагдсан элэгдлийг эхний үлдэгдлээр тайлагнасан.
2. Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны 01 сарын 08-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авсан боловч санхүүгийн тайланд бараа материалыг эхний үлдэгдлээр тайлагнасан.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Татварын хөнгөлөлтийг жилийн эцэст тооцоолоогүйгээс 16.0 мянган төгрөгөөр дутуу, 102.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3 дахь "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ." Гэсэн заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцсон татварын хөнгөлөлт болох 86.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага өгөөгүй.

5.3 Зөвлөмж өгөөгүй.

Дээрх шийдвэрийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх ба Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийг төлөвлөгөөг хуулийн хугацаанд буюу тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга										/мянган төгрөгөөр/					
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж				
							Залруулсан		Залруулаагүй						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны 01 сарын 08-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авсан боловч санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон хуримтлагдсан элэгдлийг эхний үлдэгдлээр тайлагнасан.	1	30,154.9			1	30,154.9	1	30,154.9							
Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны 01 сарын 08-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авсан боловч санхүүгийн тайланд бараа материалыг эхний үлдэгдлээр тайлагнасан	1	934.1			1	934.1	1	934.1							
Дүн	2	31,089.0			2	31,089.0	2	31,089.0							

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга		Үүнээс										/мянган төгрөгөөр/			
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Татварын хөнгөлөлтийг жилийн эцэст тооцоолоогүйгээс 16.0 мянган төгрөгөөр дутуу, 102.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.		1	86.0	1	86.0										
Дүн		1	86.0	1	86.0										

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Үүнээс						/мянган төгрөгөөр/	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил

Шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө зарцуулах 250.0 мянган төгрөгийн 1 тушаал, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсвийн байгууллагын батлагдсан төсвийн гүйцэтгэл-1 /7-р сард/, хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан тайлбар-1 /7-р сард/ хугацаа хоцорч мэдээлсэн. Мөн 5 сая төгрөгөөс дээш 5.1 сая төгрөгийн 1 худалдан авалтыг мэдээлээгүй.									
1	5,355.0				1	5,355.0			
Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	1	5,355.0			1	5,355.0			5,355.0



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 16/086 0274
ГА-2025/050/НА-СТА-ТЧЗ

Чойр

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хүрээнд Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө зарцуулах 250.0 мянган төгрөгийн 1 тушаал, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсвийн байгууллагын батлагдсан төсвийн гүйцэтгэл-1 /7-р сард/, хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан тайлбар-1 /7-р сард/ хугацаа хоцорч мэдээлсэн. Мөн 5 сая төгрөгөөс дээш 5.1 сая төгрөгийн 1 худалдан авалтыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 дахь "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг," гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд дээрх зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Б.Болд-эрдэнэ, ахлах нягтлан бодогч А.Аасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Г.НАРАНБАЯР

Б.ДАРХАНБАТ

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543479

422504053



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 15/АД860874

Чойр

ГА-2025/050/НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн "Худалдан авах ажиллагааны газар"-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг жилийн эцэст тооцоолоогүйгээс 16.0 мянган төгрөгөөр дутуу, 102.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3 дахь "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно," Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", "4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.5-д "бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцсон татварын хөнгөлөлт 86,000.0 (Наян зургаан мянга) төгрөгийг удирдлага, санхүүгийн ажилтан нар хариуцан барагдуулж, Говьсүмбэр аймгийн Төрийн сан дахь **орон нутгийн орлогын "Төсөвт байгууллагын өөрийн орлого" 100220000954** тоот дансанд төвлөрүүлэх

422505059

2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 25-ны дотор өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга, төсвийн шууд захирагч Б.Болд-эрдэнэ, ахлах нягтлан бодогч А.Аасүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Г.НАРАНБАЯР

Б.ДАРХАНБАТ

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, Нутгийн удирдлагын ордон, Утас:70543179

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Аудитын код: ГСА-2025/050НА-СТА-ТШЗ

Байгууллагын нэр: Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газар

Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагын РД: 4617894

Тайлант хугацаа: 2024.01.01-2024.12.31

2025.02.05

№	Ажил гүйцэтгэний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Ажил гүйцэтгэний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /Төг/	Аудитын байгууллага с гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын холбогдох хүний	
									Албан тушаал	Овог нэр
А		1	2	3	4	5	6	7	8	9
1. Санхүүгийн тайлангийн аудитын алдаа										
1	Нийт хөрөнгө	Үндсэн хөрөнгө	Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны 01 сарын 08-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авсан боловч санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон хуримтлагдсан элэгдлийг эхний үлдэгдлээр тайлагнасан.	30,154,884.0	Залруулга хийх				Дарга Нягтлан бодогч	Б.Болд-эрдэнэ А.Аасүрэн
2	Эргэлтийн хөрөнгө	Бараа материал	Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны 01 сарын 08-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авсан боловч санхүүгийн тайланд бараа материалыг эхний үлдэгдлээр тайлагнасан	934,150.0	Залруулга хийх				Дарга Нягтлан бодогч	Б.Болд-эрдэнэ А.Аасүрэн
Алдааны дүн				31,089,034.0						
2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил										
1	Нийт зардал	Цалингийн зардал	Татварын хөнгөлөлтийг жилийн эцэст тооцоолоогүйгээс 16.0 мянган төгрөгөөр дутуу, 102.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	86,000.0	Төлбөрийн акт тогтоох				Дарга Нягтлан бодогч	Б.Болд-эрдэнэ А.Аасүрэн
Зөрчлийн дүн				86,000.0						
3. Нийцлийн аудитын асуудлын бүртгэл										
1	Хууль тогтоомжийн хэрэгжилт	Шилэн дансны тухай хууль	Шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө зарцуулах 250.0 мянган төгрөгийн 1 тушаал, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсвийн байгууллагын батлагдсан төсвийн гүйцэтгэл-1 /7-р сард/, хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан тайлбар-1 /7-р сард/ хугацаа хоороч мэдээлсэн. Мөн 5 сая төгрөгөөс дээш 5.1 сая төгрөгийн 1 худалдан авалтыг мэдээлээгүй.	5,355,000.00	Албан шаардлага өгөх				Дарга Нягтлан бодогч	Б.Болд-эрдэнэ А.Аасүрэн
Нийцлийн асуудлын дүн				5,355,000.00						
Нийт дүн				36,530,034.00						

Бэлтгэсэн: Ахлах аудитор
Хянасан: Аудитын менежер
Хянасан: Дарга, Тэргүүлэх аудитор

Б.Дарханбат
Г.Наранбаяр
Б.Сарантуяа

421714459
УГА0055 9017099

Танилцах зөвшөөрсөн:

Дарга
Б.Болд-эрдэнэ

Ахлах нягтлан бодогч
А.Аасүрэн

3226010002

Огноо: 2025.02.05